



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ЗАХИАЛАГЧИЙН БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2024 оны 11-р сарын 12-ны өдөр

| | | |
|----|--|---|
| 1 | Төсөл арга хэмжээний нэр, байршил | Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажил |
| 2 | Төсөл хэрэгжүүлэх хууль, эрх зүйн үндэслэл | 2024 оны төсвийн тухай хууль |
| 3 | Захиалагч | “Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар” ХХК |
| 4 | Санхүүжүүлэгч | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар |
| 5 | Гүйцэтгэгч | “Цүн Түрүү” ХХК |
| 6 | Гэрээний нэр, дугаар | ОНТХО-НТШ-23/2024 |
| 7 | Зураг төсөл зохиогч | “ТГТ” ХХК |
| 8 | Гэрээний үнэ | 449,840,325 төгрөг |
| 9 | Гэрээний хугацаа | 2024.09.27 – 2024.11.20 |
| 10 | Гэрээний үнэ, хугацааг өөрчилсөн /сунгасан, нэмсэн/ бол шалтгаан | Байхгүй |
| 11 | Санхүүжилт | 407,765,937 |

1. Төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажил”-д Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газартай захиалагчийн хяналтын гэрээ байгуулан ажиллаа. “Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажил”-д буулгалтын ажил, дээврийн ажил, агааржуулах системийн ажил, халаалтын радиатор солих ажлууд хийгдсэн.

2. Захиалагчийн хяналтаар ажилласан тоо:

Төсөл хөтөлбөрийн барилга

засварын ажлын хяналтын гэрээ байгуулахаас эхлүүлэн өнөөдрийг хүртэл ажил гүйцэтгүүлэх, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулах цаашид БУА-ыг дуусгавар болгох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. БУА-ын угсралтын шатанд 4 удаа очиж ажилласан ба гүйцэтгэгч байгууллагад тухай бүр нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах

болон батлагдсан зураг төсөл, ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу угсралтын ажлыг гүйцэтгэх, зураг төслийн автор, ашиглагч байгууллагатай уялдаа холбоотой ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажиллав. Гүйцэтгэгч “Цүн Түрүү” ХХК нь захиалагч байгууллага, зураг төслийн автороос өгсөн үүрэг даалгаврыг тогтмол биелүүлэн биелэлтийг тухай бүр нь биелүүлэн ажиллаж байв. Мөн ажлын байранд ажиллаж байгаа нийт инженер техникийн ажилчдад аюулгүй ажиллагааны болон техник ашиглалтын дүрмийг чанд мөрдөн ажиллаж аваар осолгүй ажиллахыг мэдэгдэж байв.

3. Засварын ажлын явцад гарсан алдаа, зөрчил, түүнийг арилгуулсан талаар:

Барилгын засварын ажлын явцад ямар нэгэн технологийн алдаа зөрчил гараагүй. Батлагдсан зураг төслийн дагуу засварын ажил хийж байх талаар тогтмол хяналт хийж талбайн журналд тэмдэглэл хийж байсан. Өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэгч компани тогтмол арилгаж байсан.

4. Барилгын засварын ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэх: ТИЙМ

Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж, агааржуулалтын төхөөрөмж зураг төслийн дагуу суурилуулсан.

5. Ажлын зурагт өөрчлөлт орсон эсэх: ҮГҮЙ

6. Явц:


Барилгын засварын ажлын гүйцэтгэлийн шатанд захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөл хяналтаар тогтмол ажилласан. Ашигласан материалын чанарыг Дорноговь аймгийн лабораторид хянаж баталгаажуулсан. Засварын ажил бүрэн дууссан ба улсын комисс ажиллуулахаар ажиллаж байна.

7. Ашиглалтад оруулах боломжтой эсэх:

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажлыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч ГХБХБГ, гүйцэтгэгч “Цүн Түрүү” ХХК-ийн төлөөллүүд газар дээр нь шалгаж үзлээ. Ажлын явцад захиалагчийн хяналтыг ГХБХБГ-аас хэрэгжүүлж ил, далд ажлын актуудыг баталгаажуулж, барилгын засварын ажлыг норм дүрэм технологийн дагуу чанартай материалаар гүйцэтгүүлэхэд анхаарах асуудлаар заавар зөвлөмж өгс ажилласан. Иймд Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажил болон холбогдох техникийн баримт бичгийг шалгаж захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтарсан үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан тул ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах боломжтой гэсэн нэгдсэн дүгнэлтийг гаргав.

ДУГНЭЛТ ГАРГАСАН:

ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА



Ц.БАЯРМАА

ГХБХБГ-ЫН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Э.АМГАЛАНБААТАР